



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

200.1 оны 01 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоог батлах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Биеийн тамир, спортын хороо"-ны дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Биеийн тамир, спортын хорооны орон тооны хязгаарыг 5 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо /Д.Содномзундуй/-нд даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/51 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
9 дүгээр захирамжийн хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын хороо /цаашид "хороо" гэх/ нь нийслэл хотод биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар явуулах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.
- 1.2. Хороо нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.
- 1.3. Хороо нь нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.
- 1.4. Хорооны бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.
- 1.5. Хорооны дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.
- 1.6. Хорооны дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.
- 1.7. Хороо нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.
- 1.8. Хорооны даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг хорооны дарга батлана.

Хоёр. Хорооны үүрэг

- 2.1. Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.
- 2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Хорооны даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулна.

2.4. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.5. Үндэсний өв уламжлалд тулгуурлан нийслэлийн хүн амын дунд ардын тоглоом наадам, үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулан зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих.

2.6. Нийслэл хот, дүүргийн хүн амын дунд зохион байгуулах нийтийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, сургалт дасгалжуулалтын ажлыг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох.

2.7. Гадаад орнуудын биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, гэрээ хэлэлцээр хийх, хэрэгжүүлэх.

2.8. Дүүргийн спорт, сургалтын төвийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

2.9. Хорооны ажилтан, албан хаагчдын мэргэжил, мэргэшлийг нь дээшлүүлэх, давтан сургах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.10. Биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих.

2.11. Нийслэл хотод биеийн тамир, спортын арга хэмжээг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, биеийн тамир, спортыг хөгжүүлэх ажлыг нийслэлийн дүүргүүдийн Биеийн тамир, спорт сургалтын төвүүдээр дамжуулан хэрэгжүүлэх, тэднийг мэргэжлийн удирдлага, зааварчилгаар ханган хяналт тавьж ажиллах.

2.12. Биеийн тамир, спортын мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах.

2.13. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

Гурав. Хорооны эрх.

3.1. Харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөх, зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх, тэдний ажлын талаар томилсон байгууллагад нь саналаа өгөх.

3.2. Хүн амын дунд зохиох нийтийн биеийн тамир, спортын сургалтын хөтөлбөр, нэгдсэн ангилал, бусад нормативыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж саналаа өгөх.

3.3. Эрхэлсэн ажлын холбогдолтой мэдээ материалыг холбогдох газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, биеийн тамир, спортын хороо, бусад байгууллагаас гаргуулан авах.

3.4. Хорооны эрх хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тодорхой асуудал боловсруулахад зохих мэргэжлийн хүмүүсийг холбогдох байгууллагатай нь зөвшөөрөлцсөний үндсэн дээр урьж оролцуулах.

3.5. Спортын арга хэмжээний төсвийг батлуулж хуваарилан олгох, ашиглалт зарцуулалтанд хяналт тавих.

3.6. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан, спортын гарамгай амжилт гаргасан хүмүүсийг Монгол улсын алдар цол, төрийн дээд болон Засгийн газар, нийслэлийн Засаг даргын шагналаар шагнуулах саналыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад оруулах, тус хорооны шагналаар шагнах.

3.7. Тамирчид, шүүгчид, дасгалжуулагчид, биеийн тамир спортын ажилтнуудад хуулийн хүрээнд заасан хариуцлага тооцож, сахилгын арга хэмжээ авах.

3.8. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.

-----oOo-----